

**ОЮУТНЫ СУРГАЛТЫН БАГЦ ЦАГ /КРЕДИТ ЦАГ/,
ХИЧЭЭЛ ДҮЙЦҮҮЛЭХ ЗААВАР**

1. Энэхүү зааврыг Бакалаврын сургалтын журамд заасан багц цаг дүйцүүлэн тооцох тухай заалтыг хэрэгжүүлэхэд хэрэглэнэ.
2. Шилжин ирсэн болон өмнө нь бакалаврын боловсрол эзэмшсэн оюутан өөрийн хүсэлтээр сургалтын багц цаг /кр.ц/ буюу хичээл дүйцүүлэн тооцуулах санал гаргах эрхтэй бөгөөд хүсэлт гаргахаасаа өмнө Бакалаврын сургалтын журмын холбогдох заалт болон энэхүү зааврыг уншиж судалсан байвал зохино.
3. Хичээл дүйцүүлэх хүсэлтээ тухайн оюутан ХЧБА-нд тухайн улирлын хичээл эхлэхээс өмнө болон хичээл эхэлснээс хойш 14 хоногийн дотор гаргах ба дүйцүүлсэн эсэхийг 5 хоногт багтаан Сургалтын алба хариу мэдэгдэнэ.
4. Хичээл дүйцүүлэх хүсэлтийг хүлээн авах, хянах ажлыг маягт-1-ын дагуу гүйцэтгэх ажлыг ХЧБА, оюутанд тодорхойлолт олгох, дүн, кредитийг бүртгэх, системд оруулах, мэдээллэх, баталгаажуулах ажлыг Сургалтын алба, мэдэгдэл өгөх ба төлбөртэй холбоотой өөрчлөлт, шилжүүлгийг Санхүүгийн алба тус тус гүйцэтгэнэ.
5. Дүйцүүлэлтийг шилжиж ирсэн оюутны хувьд өмнөх сурч байсан сургуульд судалсан хичээлийн тодорхойлолтоор, шинээр элссэн буюу цагийн хэлбэрээр /эчнээ/ суралцах оюутны хувьд бакалаврын /магистр/ дипломын хавсралтанд бичигдсэн хичээлээр хянан /хичээлийн нэр, агуулга, кредит цаг, дүн/ дүйцүүлж болно.
6. Хичээл дүйцүүлэн тооцсон бол Сургалтын алба тухайн оюутан болон хичээл заах багшид тодорхойлолтоор мэдэгдэж, сургалтын E-Uni системд зохих өөрчлөлт оруулна.
7. Дүйцүүлэн тооцсон хичээлд суухыг тухайн оюутанд зөвшөөрөхгүй.
8. Хичээлийн кредит цаг дүйцүүлэлтийн улирлын нэгдсэн бүртгэлийг маягт-2-ын дагуу Сургалтын алба хийж хичээлийн улирлын төгсгөлд захирлын тушаалаар баталгаажуулж, төгсөхөд нь бакалаврын дипломын хавсралтад хичээлийг бичнэ.
9. Дүйцүүлсэн хичээл тус бүрийг 90,000 төгрөгөөр тооцож оюутанд буцаан олгох буюу дараагийн сургалтын төлбөрт шилжүүлэн тооцно.
10. Хичээлийн кредит цаг дүйцүүлэхэд тавигдах шаардлага:
 - Ерөнхий шаардлага:
 - 1) Тухайн дүйцүүлэх хичээл нь Сургалтын төлөвлөгөөнд батлагдсан байх.
 - 2) Дүйцүүлэх хичээлийг ойролцоо агуулга, нэршилтэй 2 хичээлээр дүйцүүлж болно.
 - 3) Тухайн хичээлийг 15 жилээс өмнө судалсан бол дүйцүүлэхгүй.
 - Кредит цагийн шаардлага:
 - 4) Нийт дүйцүүлэх кредит цагийн дээд хэмжээ 40 кр.цаг байна.
 - 5) Тухайн хичээлийн кредит цагийн зөрүү 0,5 кр.цагаас ихгүй байна.
 - Үнэлгээ, дүнгийн шаардлага:
 - 6) Тухайн хичээлийн үнэлгээ “В” буюу 80,0-аас дээш дүнтэй байх.
 - 7) Хоёр хичээлийг нэгтгэн дүйцүүлсэн бол дүнг хичээлүүдийн тоон дүнгийн нийлбэрийн дундажаар, кредит цагийг Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсанаар тус тус тооцно.
 - 8) Үнэлгээ нь тодорхойгүй, дүнд хувиргах боломжгүй /”тооцов” гм дүгнэгдсэн/ хичээлийг дүйцүүлэн тооцохгүй.

ХИЧЭЭЛ, КРЕДИТ ЦАГ ДҮЙЦҮҮЛЭН ТООЦОХ МАЯГТ

/Дүйцүүлсэн тооцсон хичээлийг баталгаажуулна/

Оюутны овог, нэр:

Оюутны код (ID):

Мэргэжил: Анги бүлэг:

САНАМЖ:

- Хичээл, багц цаг дүйцүүлэх заавартай танилцсан байх
- Хичээлийн дүн "В", түүнээс дээш байх
- Кр.цагийн зөрүү 0,5-аас ихгүй байх

Шинээр элссэн Түвшин ахисан Шилжин ирсэн Жилийн чөлөөтэй байсан

№	Төлөвлөгөөнд тусгагдсан хичээлийн нэр	Кр. цаг	Дүйцүүлэн тооцсон		Хянасан /гарын үсэг/
			Хичээлийн нэр	Кр.цаг, дүн	
1					
2					
3					
4					
5					
6					
7					
8					

Зөвшөөрсөн оюутны гарын үсэг /
/гарын үсэг/ /нэр/

Утасны дугаар:

Хянан дүйцүүлсэн: ХЧБА-ны дарга /
тэмдэг /гарын үсэг/ /нэр/

(Хичээлийн кредит цаг дүйцүүлсэн оюутны бүртгэл мэдээллийн
нэгтгэлийн загвар)

БАТЛАВ. Захирал / /

**ОЮУТНЫ СУРГАЛТЫН КРЕДИТ ЦАГ /ХИЧЭЭЛ/ ДҮЙЦҮҮЛЭЛТИЙН
НЭГДСЭН БҮРТГЭЛ**

(202...-202... оны хичээлийн жилийн ...-р улиралд
шинээр элссэн болон шилжин ирж суралцагсадын бүртгэл)

№	Оюутны нэрс	Мэргэжил, анги бүлэг	Дүйцүүлсэн хичээлийн нэрс	Кредит цаг	Дүн
1		Сэтгэл судлалын 3-р анги	1. Англи хэл 2. Сэтгэл судлалын түүх 3. Социологи 4. Улс төр судлал	3 кр. 2 кр. 2 кр. 2 кр.	95,0 /+А/ 94,0 /А/ 87,0 /+В/ 86,0 /В/
2		Сэтгэл судлалын 16 анги /эчнээ/	1. Түүх 2. Социологи 3. Англи хэл	3 кр. 2 кр. 3 кр.	77,0 /+С/ 76,0 /С/ 70,0 /С/
...					

Нэгтгэсэн: Сургалтын албаны дарга / /

202 ... он ... сар ... өдөр

БАТЛАВ. Захирал

Ч.Базар

**ОЮУТНЫ СУРГАЛТЫН КРЕДИТ ЦАГ /ХИЧЭЭЛ/ ДҮЙЦҮҮЛЭЛТИЙН
НЭГДСЭН БҮРТГЭЛ**

(202...-202... оны хичээлийн жилийн ...-р улиралд
шинээр элссэн болон шилжин ирж суралцагсадын бүртгэл)

№	Оюутны нэрс	Мэргэжил, анги бүлэг	Дүйцүүлсэн хичээлийн нэрс	Кредит цаг	Дүн
1		Сэтгэл судлалын 3-р анги	5. Англи хэл 6. Сэтгэл судлалын түүх 7. Социологи 8. Улс төр судлал	3 кр. 2 кр. 2 кр. 2 кр.	95,0 /+A/ 94,0 /A/ 87,0 /+B/ 86,0 /B/
2		Сэтгэл судлалын 16 анги /эчнээ/	4. Түүх 5. Социологи 6. Англи хэл	3 кр. 2 кр. 3 кр.	77,0 /+C/ 76,0 /C/ 70,0 /C/
...					

Нэгтгэсэн: Сургалтын албаны дарга /Э.Хоролсүрэн/

202 ... он ... сар ... өдөр

ХИЧЭЭЛ, КРЕДИТ ЦАГ ДҮЙЦҮҮЛЭН ТООЦОХ МАЯГТ

/Дүйцүүлсэн тооцсон хичээлийг баталгаажуулна/

Оюутны овог, нэр:

Оюутны код (ID):

Мэргэжил: Анги бүлэг:

САНАМЖ:

- Хичээл, багц цаг дүйцүүлэх заавартай танилцсан байх
- Хичээлийн дүн “В”, түүнээс дээш байх
- Кр.цагийн зөрүү 0,5-аас ихгүй байх

Шинээр элссэн Түвшин ахисан Шилжин ирсэн Жилийн чөлөөтэй байсан

№	Төлөвлөгөөнд тусгагдсан хичээлийн нэр	Кр. цаг	Дүйцүүлэн тооцсон		Хянасан /гарын үсэг/
			Хичээлийн нэр	Кр.цаг, дүн	
1					
2					
3					
4					
5					
6					
7					
8					

Зөвшөөрсөн оюутны гарын үсэг /
/гарын үсэг/ /нэр/

Утасны дугаар:

Хянан дүйцүүлсэн: ХЧБА-ны дарга /Л.Баярмагнай/
тэмдэг /гарын үсэг/ /нэр/

202 ... он ... сар ... өдөр